

2014 онд Монгол улс гадаадтай харилцсан гол үйл явдлын жагсаалт

- 01.17 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Японы Ерөнхий сайд Ш.Абэ нар 17-ны өдөр утсаар ярилцаж, Монгол-Японы Стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн явц болон бүс нутгийн харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. Энэ нь хоёр орны төрийн тэргүүнүүдийн утсаар ярилцсан анхны тохиолдол юм.
- 01.19-21 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Лихтенштейний Вант улсад 19-21-ний өдрүүдэд ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Лихтенштейний Эрхэм дээд Ван хоёрдугаар Ханс-Адам, Угсаа залгамжлагч Эрхэм дээд Хунтайж Алойс, Ерөнхий сайд Адриан Хаслер, Гадаад харилцаа, Боловсрол, соёлын сайд Аурелиа Фрик нартай тус тус уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцаж санал солилцов. Хоёр орны харилцаа хуулийн засаглал, хүний эрх чөлөө зэрэг нийтлэг үнэт зүйлсэд тулгуурласан бөгөөд үнэт зүйлд том, жижиг гэдэг ойлголт байдаггүй, энэ утгаараа хоёр улсын харилцаа өргөжин хөгжиж байгааг хоёр тал санал нэгтэй онцлон тэмдэглэв. Монгол Улс, Лихтенштейний Вант улстай 16 жилийн өмнө дипломат харилцаа тогтоосон бөгөөд өмнө нь Ерөнхийлөгч Н.Багабанди, Н.Энхбаяр нар тус улсад айлчлал хийж байжээ. Уулзалтынхаа үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Эрхэм дээд Ван болон Угсаа залгамжлагч Эрхэм дээд хунтайж нарыг Монгол Улсад айлчлахыг урив.

- 01.22-25 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 22-25-нд Швейцарийн Давостод болох Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцов. “Дэлхий ертөнцийг шинэчлэн өөрчлөх нь: Нийгэм, улс төр, бизнест үзүүлэх үр дагавар” сэдвийн дор зохион байгуулагдах энэ удаагийн чуулга уулзалтад улс төр, бизнес, иргэний нийгмийг төлөөлж 2700 гаруй төлөөлөгч оролцон, дэлхий нийтийн өмнө тулгарч байгаа болон шинэ сорилтуудыг даван туулах арга замыг тодорхойлсон байна. Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын эхний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Японы Ерөнхий сайд Шинзо Абэтэй уулзаж хоёр орны харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны ярилцав.
- 02.05 Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн нээлтийн ёслолын арга хэмжээ Гадаад харилцааны яаманд болов. Гадаад харилцааны сайд Л.Болд, Монгол Улс дахь ХБНГУ-ын хэргийг түр хамаарагч Б.Дюкофр нар тус арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өдгөө нийгмийн бүхий л салбарыг хамран, “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд өргөжин тэлж буйд баяртай байгаагаа тэмдэглэв. Хоёр улс 1974 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр дипломат харилцаа тогтоожээ.
- 02.14 Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Алтангэрэл тус улсын Ерөнхийлөгч Энрике Пена Ниетод 14-ний өдөр Итгэмжлэх жуух бичгээ барив. Монгол, Мексикийн хооронд 1975 оны 9 дүгээр сарын 24-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд ирэх жил тохиох дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн үеэр хоёр талдаа зохион байгуулж, хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар Элчин сайд Мексикийн холбогдох талуудтай ярилцаж санал солилцлоо.
- 02.24 Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 42 жилийн ой 24-ний өдөр тохиож буйтай холбогдуулан ГХЯ болон Монгол, Японы Түншийн холбоо,

ОЛОН УЛС СУДЛАЛ

Монгол, Японы найрамдлын нийгэмлэг, Японд суралцсан оюутнуудын холбоо “Жугамо” нийгэмлэг хамтран Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд Т.Шимизү болон Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дипломат ажилтнуудад хүндэтгэлтэйгээр тэмдэглэв.

03.10 Монгол Улс, Тайландын Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн баяр 10-нд ГХЯ-нд болж, Гадаад харилцааны сайд Л.Болд болон төр, засгийн байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, Улаанбаатар дахь дипломат корпус, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төлөөлөгчид болон найрамдлын нийгэмлэгийн удирдлага, Тайландын Вант Улсын Өргөмжит консул нар оролцов. Сайд Л.Болд ойн баярыг нээж хэлсэн үгэндээ өнгөрсөн 40 жилийн хугацаанд Монгол, Тайландын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа олон чиглэлд хөгжиж, өндөр дээд хэмжээний айлчлалууд харилцан амжилттай хэрэгжсэн, мөн уул уурхай, аялал жуулчлал, соёл зэрэг салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжууд нээгдсэнийг тэмдэглэв. Тайландын Ерөнхий сайд Ч.Йинглакын 2013 онд Монгол Улсад хийсэн анхны албан ёсны айлчлал нь Монгол, Тайландын ард түмнийг улам ойртуулж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны шинэ түүхийг нээж, харилцааны үндсийг бэхжүүлснээрээ түүхэн ач холбогдолтой болсныг мөн онцлов.

04.12-15 Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Холбооны Парламентын дарга Тура У Шве Манн Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар 12-15-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Мьянмарын Холбооны Парламентын дарга Тура У Шве Манн Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд нар албан ёсны хэлэлцээ хийж, Ерөнхий сайд Н.Алтанхуяг хүлээн авч уулзав. Энэхүү айлчлал нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2013 онд тус улсад хийсэн төрийн айлчлалын үр дүнд Мьянмарын талаас хэрэгжих

гэж буй өндөр, дээд түвшний анхны айлчлал гэдгээрээ онцлог юм. Айлчлалын үеэр Монгол, Мьянмарын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хоёр орны хууль тогтоох байгууллага хооронд харилцаа холбоо тогтоох, ардчилал, иргэний нийгмийн замыг сонгон шилжилтийн үйл явцыг эхлүүлээд буй Мьянмар Улсад Монгол Улсын ардчилал, нийгэм, эдийн засгийн шилжилт хийсэн туршлага солилцох болон олон улсын тавцанд хамтран ажиллах зэрэг өргөн хүрээний асуудлаар санал солилцлоо.

04.25 Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой, “Монгол Улс, БНХАУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулсны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болсон. Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ 25-ны өдөр Бээжин хотноо зохион байгуулав. Эрдэм шинжилгээний хурлыг нээж Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ц.Сүхбаатар үг хэлэв. Манай талаас Гадаад харилцааны сайд асан Ц.Гомбосүрэн үндсэн илтгэлийг тавьж, ШУА-ийн ОУСХ-ийн захирал Д.Шүрхүү, Стратеги судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Индра, хятадын талаас НШУА-ийн Ази, Номхон далай, стратеги судлалын хүрээлэнгийн захирал Ли Сян-ян, Төрийн Зөвлөлийн Судалгааны төвийн судлаач Ван Иминь, НШУА-ийн Угсаатан, антропологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Бао Шэнли нар тус тус илтгэл тавив.

05.02 Монгол Улс Зүүн өмнөд Азийн орнуудтай найрсаг харилцаагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутгийн олон талт яриа хэлэлцээний интеграцид нэгдэн орох явцыг идэвхижүүлэх зорилтын хүрээнд тус бүс нутгийн орнуудаар Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Д.Ганхуяг Камбожийн Вант Улсад хүрэлцэн очиж, хоёр улсын Гадаад харилцааны яамд хоорондын анхны зөвлөлдөх уулзалтыг тус улсын Гадаад хэрэг, олон улсын хамтын ажиллагааны

яамны Төрийн нарийн бичгийн дарга Лун Висало-тай хийв. Хоёр улс 1960 онд дипломат харилцаа тогтоосон боловч, сүүлийн гуч гаруй жил зогсонги байсан хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг шинэ нөхцөлд зохицуулан бүхий л бололцоотой салбарт идэвхижүүлэн хөгжүүлэхийн чухлыг талууд харилцан тэмдэглээд, энэ хүрээнд ГХЯ-д хооронд хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурав. Зөвлөлдөх уулзалтын үеэр, хамтын ажиллагааг хөгжүүлж болох тодорхой салбарууд болон ирэх онд тохиох дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн арга хэмжээний талаар талууд санал солилцож, Монгол Улсын Зүүн Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны механизм, түүний дотор Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтад нэгдэн орох, АСЕАН-ы Яриа хэлэлцээний түнш болох хүсэл эрмэлзэлийг Камбожийн тал дэмжиж ажиллахаа илэрхийлэв.

05.20-21 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тавдугаар сарын 20-21-ний өдрүүдэд БНХАУ-ын Шанхай хотноо болсон Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх Бага хурал / АХАИББХ/-ын Дээд хэмжээний IV ээлжит уулзалтад оролцов. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АХАИББХ-ын Дээд хэмжээний уулзалтад үг хэлж, Бага хурлын гишүүн орнуудтай хамтран ажиллах, бүс нутгийн хамтын ажиллагаанд хамрагдах чиглэлээр баримталж буй Монгол Улсын бодлого, байр суурийг илэрхийлэхээс гадна БНХАУ-ын дарга Си Зиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин болон бусад зарим орны төрийн тэргүүн нартай хоёр талын уулзалт хийв.

05.22 ОХУ-ын Санкт-Петербург хотод зохион байгуулагдсан Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцсон Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхугийг ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Эдийн засгийн чуулганы урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Монгол Улсын Ерөнхий сайдад талархал илэрхийлээд, талууд хоёр улсын цаашдын хамтын ажиллагаа болон эдийн засгийн асуудлаар

санал солилцон, төмөр зам, хоёр орны хамтарсан үйлдвэрүүд зэрэг олон асуудлыг хөндөн ярилцсан байна.

- 06.11-13 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Латви Улсын Ерөнхийлөгч Андрис Берзинш 11-13-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Энэхүү айлчлал нь Латви Улсын Ерөнхийлөгчийн түвшинд Монгол Улсад хийгдэж буй анхны айлчлал юм. Европын Холбоо болон НАТО-гийн гишүүн, эдийн засгийн хямралыг үлгэр жишээ даван туулж, эдийн засгаа эрчимтэй хөгжүүлж буй Латви Улстай хоёр талын харилцааг идэвхжүүлэх талаар ярилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход энэхүү айлчлал чухал ач холбогдолтой болов. Монгол Улс шинээр тусгаар тогтносон Бүгд Найрамдах Латви Улстай 1991 оны 10 дугаар сарын 15-нд дипломат харилцаа тогтоосон. Бүгд Найрамдах Латви Улсын Ерөнхийлөгч Андрис Берзинш Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг тааламжтай цагтаа Бүгд Найрамдах Латви Улсад айлчлахыг урив.
- 07.03 НҮБ-ын гишүүн бүх улстай Монгол Улс дипломат харилцаа тогтоох зорилтын хүрээнд Монгол Улс Бүгд Найрамдах Маврики Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов. Хоёр улс найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх хоёр талын эрмэлзлийг удирдлага болгож, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн зарчмуудыг баримтлахаа тохиролцож, дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд О.Оч, БНМУ-аас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Милан Жаяа Н.Меетарбхан нар гарын үсэг зурав.
- 07.08-12 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн урилгаар Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхий сайд Д.К.Оторбаев 7 дугаар сарын 8-12-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийв. Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхий сайд

Джоомарт Кайпович Оторбаевын Монгол Улсад хийж байгаа ажлын айлчлал нь хоёр орны хамтын ажиллагааны түүхэнд шинэ хуудас нээж байгааг Ерөнхий сайд Н.Алтанхуяг хэлээд хэлэлцээний үеэр Монгол, Киргиз хоёр улс нь парламентын ардчиллыг хөгжүүлэх чиглэлд цаашид бие биедээ дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаа илэрхийлэв.

07.23 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсад ажлын айлчлал хийж. Япон Улсын Парламентын Зөвлөхүүдийн танхим дахь Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга С.Эда бараалхлаа. Ноён С.Эда Парламент хоорондын харилцааг хөгжүүлэх чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллана. Мөн Монгол Японы хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээ зарчмын тохиролцоонд хүрсэн нь хоёр улсын харилцаанд чухал ач холбогдолтойг онцлоод батлахад нь Япон улсын Парламентын зүгээс бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана гэдгээ илэрхийллээ. Богино хугацаанд шахуу хөтөлбөртэй хийгдэж байгаа ажлын айлчлалын дараагийн уулзалт Шизүока мужийн захирагч Х. Кавакацү бараалхсан. Фүжи уулаараа алдартай Шизүока муж нь маш олон салбарт манай улстай хамтран ажилладаг. Манай улсын орон нутагтай шууд харилцаатай ажилладаг тус мужид боловсруулах үйлдвэр олон байдаг тул сүүлийн жилүүдэд эдийн засгийн чиглэлээр хамтын ажиллагаа өргөжиж байгаа. Манай улсын нүүрсний салбарт боловсон хүчин, инженерүүдийг бэлтгэх асуудал ярилцсан. Мөн цаашид харилцаагаа улам өргөжүүлбэ зөвхөн Шизүока муж төдийгүй Японы бусад мужийн захирагчдыг манай орон нутгийн удирдлагуудтай шууд холбож өгөх боломжтой гэсэн асуудлуудыг ярилцлаа.

08.21-22 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар төрийн айлчлал хийж байгаа БНХАУ-ын дарга Си Зиньпинд УИХ-ын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар бараалхав. Мөн УИХ-ын хүндэтгэлийн чуулган хуралдаж БНХАУ-ын дарга Си Зиньпин үг хэллээ. Уг хүндэтгэлийн

чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж болон УИХ, Засгийн газрын гишүүд, Монгол Улсад гадаад орнуудаас суугаа дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нар, албаны бусад хүмүүс, БНХАУ-ын даргын айлчлалын бүрэлдэхүүнд багтсан зочид төлөөлөгчид оролцов. БНХАУ-ын дарга Хүндэтгэлийн чуулганд хэлсэн үгэндээ хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн жилд Хятад-Монголын харилцаа Иж бүрэн стратегийн харилцааны түвшинд шилжин шинэ түүхээ эхлүүлж байгааг онцлон тэмдэглэлээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНХАУ-ын дарга Си Жиньпин нар албан ёсны хэлэлцээ хийлээ. Хэлэлцээний эхэнд БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн айлчлалаас 11 жилийн дараа Хятад улсын дарга Монгол Улсад дахин төрийн айлчлал хийж буйг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж онцлон дурдав.

Албан ёсны хэлэлцээний үр дүнд хоёр тал дараах баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

1. Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНХАУ-ын дарга Си Жиньпин нар гарын үсэг зурав.

2. Монгол, Хятадын хооронд 1949-2012 онд байгуулсан хоёр талт гэрээний үйлчлэлийн талаарх Засгийн газар хоорондын протокол

3. Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын Гадаад хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны протокол

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И нар тус тус гарын үсэг зурав.

4. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын гэрээ”-ний батламж жуух бичгийг солилцох протокол

Монгол Улсын Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И нар гарын үсэг зурав.

5. Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр

Монгол Улсын Зам, тээврийн сайд А.Гансүх, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И нар гарын үсэг зурав.

6. Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр

7. Төмөр замын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

8. “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, БНХАУ-ын Улсын Төмөр замын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

Монгол Улсын Зам, тээврийн сайд А.Гансүх, БНХАУ-ын Тээврийн яамны дэд сайд бөгөөд Төмөр замын газрын дарга Лу Дун Фу нар тус тус гарын үсэг зурав.

9. Монгол Улсын Уул, уурхайн яам, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хооронд нүүрсний гүн боловсруулалтыг эрчимжүүлэх салбарын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг

Монгол Улсын Уул, уурхайн сайд Д.Ганхуяг, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны дарга Сю Шаоши нар гарын үсэг зурав.

10. Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын зөвлөл байгуулах тухай Монгол Улсын Эдийн Засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны дарга Сю Шаоши нар гарын үсэг зурав.

11. Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр

12. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газархоорондын хэлэлцээр

13. Хятадын талын тусламжаар Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгуулах төслийг эхлүүлэх тухай Засгийн газар хоорондын солилцох захидал

14. Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах тухай Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, БНХАУ-ын Худалдааны сайд Гао Хучен нар тус тус гарын үсэг зурав.

15. Монгол Улсын Эдийн Засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хятадын Экспорт-Импорт банк хооронд байгуулах “Цахим эрүүл мэнд” төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр

16. Монгол Улсын Эдийн Засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хятадын Экспорт- Импорт банк хооронд байгуулах “Шинэ зууны боловсрол төсөл”-ийн тусгайлсан зээлийн хэлэлцээр

17. Монгол Улсын Эдийн Засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хятадын Экспорт-Импорт банк хооронд байгуулах “Том оврын тракторын худалдан авах төсөл”-ийн тусгайлсан зээлийн хэлэлцээр

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр БНХАУ-ын Экспорт, импорт банкны ерөнхийлөгч Ли Руогу нар тус тус гарын үсэг зурав.

18. Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комисс байгуулах тухай Монгол Улсын Боомтын үндэсний зөвлөл, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын хэлэлцээр

Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэг, БНХАУ-ын ГЕГ-ын дарга Юй Гуанжоу нар гарын үсэг зурав.

19. Монгол Улсын ССАЖЯ, БНХАУ-ын Соёлын яам хоорондын соёлын солилцооны протокол

Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл, БНХАУ-ын Соёлын сайд Цай У нар гарын үсэг зурав.

20. Монгол Банк, Хятадын Банкны хяналтын хороо хоорондын хяналтын хамтын ажиллагааны санамж бичиг

Монгол Банкны Ерөнхийлөгч Н.Золжаргал, Хятадын Банкны Хяналтын хорооны дарга Шан Фүлин нар гарын үсэг зурав.

21. Хамтын ажиллагааны тухай Газрын тосны газар, Хятадын Газрын тосны үндэсний корпораци хоорондын санамж бичиг

Монгол Улсын Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Хятадын Газрын Тосны Үндэсний корпорацийн дэд ерөнхийлөгч Лиу Хунгбин нар гарын үсэг зурав.

22. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооллын Г хэсэг орон сууцны хорооллын төслийг хэрэгжүүлэх Төрийн орон сууцны корпораци, Хятадын Экспорт-импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр

Төрийн орон сууцны корпорацийн Ерөнхий захирал А.Гантулга, БНХАУ-ын Экспорт, импорт банкны ерөнхийлөгч Ли Руогу нар гарын үсэг зурав.

23. 162 сая ам долларын арилжааны зээлийн тухай Монгол Улсын Хөгжлийн банк, БНХАУ-ын Хөгжлийн банк хоорондын хэлэлцээр

Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Н.Мөнхбат, БНХАУ-ын Хөгжлийн банкны Ерөнхийлөгч Жэн Жизне нар гарын үсэг зурав.

24. Гашуун сухайт-Ганц модны боомтын төмөр замыг санхүүжүүлэх тухай Гашуун сухайт ХХК, БНХАУ-ын Шэнхуа групп, Хятадын хөгжлийн банк хоорондын ерөнхий хэлэлцээр

“Гашуун сухайтын төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Ганболд, БНХАУ-ын Шэнхуа группийн Ерөнхийлөгч Жан Юйжуо нар гарын үсэг зурав.

09.03 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсад ажлын айлчлал хийсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах ёслолд оролцов. ОХУ-ын Ерөнхийлөгчийн ажлын айлчлалын үеэр хоёр улсын Засгийн газар болон холбогдох байгууллага хооронд дараахь баримт бичгүүдийг байгуулав. Үүнд:

1. Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
2. Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
3. Ойг гал түймрээс хамгаалах тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
4. Иргэний нисэхийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, ОХУ-ын Тээврийн яам хоорондын санамж бичиг
5. Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай Монгол Улсын Зам тээврийн яам, ОХУ-ын “Оросын төмөр зам” НХ нийгэмлэг хоорондын хэлэлцээр
6. Хамтран ажиллах тухай хоёр улсын Хууль зүйн яам хоорондын хэлэлцээр
7. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, ОХУ-ын Барилга, орон сууц-нийтийн аж ахуйн яам хоорондын санамж бичиг
8. Монгол-Оросын эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд хамтран ажиллах тухай хоёр улсын Эдийн засгийн хөгжлийн яам хоорондын санамж бичиг
9. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, “Газрын тосны Роснефть” НХ нийгэмлэг хоорондын хэлэлцээр
10. Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн

- үйлчлэлийг сунгах тухай протокол
11. Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Сангийн яам, ОХУ-ын Холбооны төрийн сан хоорондын санамж бичиг
 12. Монгол Улсын Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, ОХУ-ын Холбооны шилжилт хөдөлгөөний алба хоорондын санамж бичиг
 13. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, ОХУ-ын “Россия сегодня” Олон улсын мэдээллийн агентлаг хоорондын санамж бичиг
 14. Хамтран ажиллах тухай “МИАТ” ХК болон “Аэрофлот” компани хоорондын санамж бичиг зэрэгт гарын үсэг зурлаа.
- 09.11-12 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нар есдүгээр сарын 11-нд Душанбе хотноо Кохи Сомон ордонд уулзав. Уулзалтын үеэр талууд гурван талын уулзалтыг тогтмолжуулах болон хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлүүдийн талаар ярилцлаа. Мөн Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 14 дэх удаагийн хуралдаанд оролцоод оролцов. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талын дээд түвшний “Улаанбаатарын уулзалт”-ыг зохион байгуулах асуудлаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нартай уулзаж ярилцсан.
- 10.16-17 Ази-Европын уулзалт (Asia-Europe Meeting) буюу АСЕМ-ын дээд түвшний уулзалт Италийн Милан хотноо өнөөдөр (10-р сарын 16) эхлэв. Дээд түвшний уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож байна. Энэхүү уулзалт нь Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой үйл явц бөгөөд Европын Холбооны гишүүн 27 улс, Европын 2 орон, (Норвеги, Швейцарь), Зүүн Өмнөд Азийн улсуудын

холбоо (ASIAN)–ны гишүүн 10 орон, Зүүн Хойд Азийн 10 орон Австрали, БНХАУ, Монгол, Мьянмар, ОХУ, Пакистан, БНСУ, Шинэ Зеланд, Энэтхэг, Япон болон Европын Комисс АСЕАН-ны Нарийн бичгийн даргын газар, нийт 51 улс, байгууллага АСЕМ-ын гишүүнээр ажиллаж байна. Энэ жил 2 улс нэмэгдэж байгаа юм байна. 2016 онд АСЕМ-ыг даргалж, уулзалтыг зохион байгуулах орноор Монгол Улсыг олонхийн саналаар сонголоо.

- 11.05 1. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид энэ өдөр Бүгд найрамдах Конго, Арабын Бүгд найрамдах Египет, Европын холбоо, Унгар, Бүгд найрамдах Кипр улсын Элчин сайд нар Итгэмжлэх жуух бичиг барив. Арабын Бүгд найрамдах Египет улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Магди Махмоуд Хелмитэй хийсэн уулзалтын үеэр Монгол Улс нь ардчилалд амжилттай шилжиж үлгэр дуурайлал болсон орон гэдгийг Египетэд сайн мэднэ гээд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш 51 жил болж буйг тэмдэглэж харилцаагаа цаашид өргөжүүлэхийн төлөө ажиллана гэдгээ илэрхийлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч ирэх 2015 онд Монголын анхны ардчилсан сонгуулийн 25 жилийн ой болох гэж байгааг тэмдэглэж, Египет улсын Ерөнхийлөгч Абдел Фаттах Сисид чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж буйг уламжилж өгөхийг хүслээ.
2. Европын холбооноос Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ханс Дитмар Швайггтэй хийсэн уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч энэ жил хоёр талын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ой тохиож буйг тэмдэглэлээ. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол Улс, Европын холбооны хооронд гурав дахь хөршийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж ирснийг мөн дурдав. Энэ хугацаанд Европын холбоо Монгол Улсын гадаад худалдааны гурав дахь том түнш болсон гэлээ. Өнгөрсөн 2013 онд Монгол Улс, Европын Холбооны Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоёр талын харилцаанд илүү их түлхэц өгч буйг тэмдэглээд Европын

холбооны Ерөнхийлөгчөөр шинээр сонгогдсон Жан Клауд Жанкерт халуун дотно мэндчилгээ дэвшүүлээ.

3. Унгар улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Цецилиа Силаштай уулзах үеэрээ ирэх жил хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиох гэж буйг тэмдэглэж энэ үеэр Унгарын талаас Элчин сайдын яамаа Улаанбаатарт сэргээн байгуулах талаар санал дэвшүүлж буйг дурдлаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн саяхан Унгарт хийсэн ажлын айлчлал амжилттай болсон гээд айлчлалын үеэр ярилцсан асуудлуудыг ажил хэрэг болгох талаар хоёр тал хамтран ажиллана гэдгийг тэмдэглэв.

4. Бүгд найрамдах Кипр улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Агис Лоизутай хийсэн уулзалтын үеэр хоёр тал боловсрол, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт хамран ажиллах боломж их байгааг тэмдэглэв. Ялангуяа боловсролын хамтын ажиллагааг ихээхэн үр дүнтэй хөгжүүлэх боломжтой гэлээ.

11.08 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бээжин хотод болсон АПЕК буюу Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын дээд түвшний уулзалтад оролцов. Монгол Улс АПЕК-ийн уулзалтад анх удаа Ерөнхийлөгчийн түвшинд, зочны хувиар оролцож байгаа юм. АПЕК-ийн энэ удаагийн хурлыг “Ирээдүйд хандсан Ази, Номхон далайн бүсийн түншлэлийн харилцааг хамтдаа байгуулъя” гэсэн гол сэдвийн дор зохион байгуулсан байна.

11.18 Олон улсын санхүүгийн төв Хонконгт жилд ганцхан удаа болдог Монголын хөрөнгө оруулалтын ээлжит чуулга уулзалт Хонконгийн Шератон буудалд эхэллээ. Монголын эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалтын идэвхжил нэн чухал байгаа эгзэгтэй цаг мөчид, манай шинэ Засгийн газар байгуулагдахаар улс төрийн яриа хэлцэл ид явагдаж байгаа өдрүүдэд олон улсын болон Ази, Номхон далайн бүс нутгийн хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж,

тухайн жилд тэдний Монголд чиглэсэн үйл ажиллагаа, хандлагыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг томоохон арга хэмжээ ийнхүү нээгдэж байна.

- 12.10 АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-ын Гүйцэтгэх захирал Дэйна Ж.Хайд 12 дугаар сарын 11-ний орой Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой утсаар ярьж, МСК-ын Удирдах зөвлөл 12 дугаар сарын 10-нд хуралдаж, Монгол Улсыг Мянганы сорилтын сангийн тусламжид 2 дахь удаа хамруулахаар шийдвэрлэснээ албан ёсоор мэдэгдэв. МСК-ын Удирдах зөвлөлийн 10-ны өдрийн хуралдаанаар Монгол, Филиппин, Непалыг тусламжид шинээр хамруулах, Кот-д Ивуар, Сьерра Леоныг бэлтгэл хөтөлбөрт хамруулах, түүнчлэн өмнөх онд сонгон шалгаруулсан 6 оронтой хамтын ажиллагааг үргэлжлүүлэх шийдвэр гаргасан байна. Мянганы сорилтын сангийн тусламжид хамрагдах орнууд эхний ээлжинд АНУ-тай хамтран хоёр талын эдийн засагч, судлаачдын оролцоо бүхий судалгааны баг байгуулж, эдийн засгийн судалгаа хийсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлэх салбар, чиглэлийг тодорхойлдог. Энэхүү судалгааг дунджаар 4-6 сарын хугацаанд хийдэг бөгөөд гэрээг эцэслэн байгуултал 2 жил гаруйн хугацаа шаардагддаг жишиг байдаг.

Г.Онон –ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан